

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Гүйцэтгэлийн удирдлагын баримт бичиг

**БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

Байгууллагын нэр: **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНХУЯГ

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.БОЛОРМАА

2025 он

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

1.Хяналт- шинжилгээний зорилго:

Төсвийн ерөнхийлөн захирагч /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллгааг сайжруулах санал, зөвлөмж өгөх, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад оршино.

2.Арга, аргачлал:

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” -ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний /2025 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар буюу хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр/ нэгтгэсэн явцын тайлан, мэдээ, мэдээллийг үндэслэн холбогдох албан тушаалтнуудаас тодруулга авах, ярилцах зэргээр тулган шалгах арга зүйг ашиглаж хэрэгжүүлэв.

3.Ерөнхий мэдээлэл:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 9 зорилтын 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 19 арга хэмжээ;
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 2 зорилт, 9 арга хэмжээ;
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 2 зорилт, 11 арга хэмжээ;
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилт, 30 арга хэмжээ байна.

Дээрх зорилт арга хэмжээнээс зорилт, арга хэмжээ давхардаж тусгагдсан 1 арга хэмжээ байна.(Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.4 болон 4.1.7-д заасан “Жендэрийн эрх тэгш байдлыг ханган Жендэрийн дэд зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, судалгаа мэдээг гарган ажиллах”)

4.Үр дүн:

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харуулбал:

4.1.1. **“Бүрэн хангалттай”** буюу 85 буюу түүнээс дээш хувиар (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн) үнэлэгдсэн 62 арга хэмжээ байна. Үүнд:

- 100 хувийн биелэлттэй 43 арга хэмжээ;
- 85-95 хувийн биелэлттэй 19 арга хэмжээ;

4.1.2. **“Хангалттай”** буюу 70-84.3 хувиар (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах) үнэлэгдсэн 6 арга хэмжээ;

4.1.3. **“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”** 1 арга хэмжээ байна.

4.2. Цаашид холбогдох газруудтай хамтран гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай 70-84.3 хувийн гүйцэтгэлтэй 6 арга хэмжээг харуулбал:

- Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдлээс 15-аас доошгүй хувиар бууруулах; (**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.3 дахь арга хэмжээ**);
(Тайлбар: Авлага барагдуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлсэн боловч нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн хэмжээ буураагүй)
- Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх; (**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.5 дахь арга хэмжээ**);
(Тайлбар: Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт хангалтгүй, тайлан мэдээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээгүй)
- Ажилгүйдлийн даатгалын сан 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх; (**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.6 дахь арга хэмжээ**);
(Тайлбар: Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт хангалтгүй)
- Иргэд, даатгуулагчдад утсаар (Callpro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; (**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.2.3 дахь арга хэмжээ**);
(Тайлбар: Дуудлага алдалтын хувь 18-аас доошгүй байхаас 24 байна)
- Жендэрийн эрх тэгш байдлыг ханган Жендэрийн дэд зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, холбогдох газарт судалгаа мэдээг гарган ажиллах (**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.4 дэх арга хэмжээ**);
(Тайлбар: Төлөвлөгөө баталсан боловч тодорхой арга хэмжээг хэрэгжүүлээгүй, судалгаа гаргаагүй)
- Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд гаргасан “Нийгмийн даатгалын байгууллагад тулгамдаж буй асуудал, үүсч болох эрсдэлийн судалгаа”-нд үндэслэн эрсдэлийг арилгах

арга хэмжээг зохион байгуулах; **(Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.6 дахь арга хэмжээ);**

(Тайлбар:Шүүхийн шийдвэрийн цахим архивын сан бүрдүүлсэн боловч бусад тулгамдсан асуудлыг тодорхойлж эрсдэлийн судалгаа хийгээгүй.)

5.Дүгнэлт

5.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг **94.8** хувиар дүгнэж **“Бүрэн хангалттай”** гэж дүгнэлээ.

5.2.Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай холбоотой дээд газраас гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт харьцангуй шуурхай, тогтмол хийгдэж байгаа нь зорилт, арга хэмжээний явц, үр дүнгээс харагдаж байгаа боловч зорилт, арга хэмжээ (үр дүн хүлээгдэж байгаа хангалттай, хугацаа болоогүй арга хэмжээ)-г жилийн эцэст зорилтот түвшинд бүрэн хүргэх, шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоох, зарим арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж үр дүнг тооцох шаардлагатай байна.

6. Зөвлөмж

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Үүнд:

Зохион байгуулалтын нэгжийн дарга нарт:

6.1.Төлөвлөлтийн хүрээнд:

- 6.1.1.Зорилт, арга хэмжээг оновчтой тодорхойлох;
- 6.1.2.Шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжигдэхүйц, тодорхой, цаг хугацаатай байхаар тусгах;
- 6.1.3.Суурь болон зорилтод түвшинг тооцоо судалгаанд үндэслэн бодитой тодорхойлох;
- 6.1.4.Төлөвлөсөн арга хэмжээний зорилтот түвшинг суурь түвшинд үндэслэн ач холбогдолтой, оновчтой байхаар төлөвлөх;
- 6.1.5.Төлөвлөгөөнд мэдээллийн эх сурвалж, гарах зардал, хаана, хэзээ тайлагнах, хэрэгжүүлэх хугацаа тодорхой байхаар тусган боловсруулах;

6.2. Зорилт арга хэмжээний хэрэгжилтийн явц, биелэлтийг тайлагнахад тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг товч бөгөөд тодорхой бичих, тухайн арга хэмжээний гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцлийг тодорхой дурдах, биелэлт дутуу, үр дүн муу арга хэмжээг дараа жилийн төлөвлөгөөнд тусгах, мөн холбогдох нотлох баримт бичгийг хавсарган ирүүлж байх

6.3. 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд хяналт-шинжилгээ хийлгэх шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан, үнэлгээний товчоог хавсаргав.

--oOo--